

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа /Жилий нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/	2024 оны 1 дүгээр сарын 01- ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Үнэт цаас гаргагчийн нэр УБГД: 9011110110 үнэт цаасны код MNOGAZR05653 утасны дугаар 75059999
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хүнсний үйлдвэрлэл
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Солид Юнити аудит ХХК
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,198,113,207
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: П.Нямдорж /ТУЗ-ийн НБД/ Хянасан: Ц.Ганбат /Гүйцэтгэх захирал/

1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Санхүүгийн тайланг хавсаргав
	Орлогын тайлан	Санхүүгийн тайланг хавсаргав
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Санхүүгийн тайланг хавсаргав

	Мөнгөн гүйлгээний тайлан	Санхүүгийн тайланг хавсаргав
--	--------------------------	------------------------------

1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
------	--	--

3. ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Газар Шим Үйлдвэр ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид Газар Шим Үйлдвэр ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү санхүүгийн тайлангууд нь Газар Шим Үйлдвэр ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд ("СТОУС")-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн баталсан Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид "НБЕЗОУСЗ-ийн Ёс зүйн Дүрэм" гэх) болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байж, НБЕЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн их ач холбогдолтой асуудлуудыг бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмжийг ашиглан аудитын гол асуудалд оруулсан. Бид санхүүгийн тайлангийн дүгнэлтийн хэлбэрийг сонгохдоо эдгээр асуудалд анхаарсан ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй. Бид дараах асуудлуудыг Аудитын гол асуудал гэж тодорхойлсон болно.

8

Газрын шинжлэл амьдралд амт нэмнэ

1.2.

Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидалыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/

Аудитын тайланг хавсаргав

2.

Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл

2.1.

Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/

Нийт хөрөнгийн өгөөж (ROA) – 12.3%
Эздийн өмчийн өгөөж (ROE) – 14.6%
Бараа материалын эргэц (өдрөөр) – 192
Авлагын эргэц (өдрөөр) - 50

2.2.

Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт

Эргэлтийн харьцаа – 6.94
ТТГЧХ – 4.15
Бэлэн мөнгөний харьцаа – 1.32

2.3.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл

Зах зээлийн эрсдэлтэй нөхцөл байдал үүсээгүй үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүй.

2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Байхгүй
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдсэн.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	

	Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хийгдээгүй.	
4.	Цалин урамшууллын мэдээлэл	
	Компанийн ТУЗ-өөс батлагдсан төсвийн хүрээнд цалингийн сүлжээний дагуу олгодог.	
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд цалин урамшуулал, нэр дэвшүүлэх, аудит, маркетингийн гэсэн 4 хороотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд 6 хуралдаж нийт 17 тогтоол гаргасан. Үүнд: Ногдол ашиг тараах болон компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, санхүү үйл ажиллагааны тайлан баталж дүгнэлт гаргах, аудитын компани сонгон шалгаруулах, 2025 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах, компанийн засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмуудыг хэлэлцэн баталж ажилласан.	
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл	
	Байхгүй	
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/	
	- Цээпэл Ганбат 42.64 % - Цээпил Төгсөө 11.01 % - Занашир Байгалмаа 9.18 % - Мелцер Штеффен 12.52 %	
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл	

ХҮНСНИЙ НОГООНЫ МЕХАНИКЖСАН АГУУЛАХ



Төлөвлөлт :
 Ногооны зоорь – 2,400 тонн
 Цаашид энэхүү зоорийг түшиглэн
 Гүн хөргөлтийн зоорь – 1,000 тонн
 Зориулалт – Хүнсний ногоо, жимсний анхан
 шатны боловсруулалт хийж, зах зээлд зориулсан
 хагас боловсруулсан бүтээгдэхүүн, гүн
 хөлдөөсөн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
 Бүтэц – Оффисын хэсэг, Ажилчдын цайны
 газар, хувцас солих өрөө, Лаборатори, 220 мкв
 талбайтай Нэрийн дэлгүүр, Кафе

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Үйл ажиллагаа	Төлөвлөгөө	Зарцуулалт	Зарцуулалтын хувь
Хүнсний ногооны зоорь барих	5,538,000,000	4,948,010,784	89.35%
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт	2,891,000,000	2,639,226,407	91.29%
Бэлтгэл дамжлагын автоматжуулалт	1,000,000,000	921,913,067	92.19%
Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт	1,070,000,000	1,989,849,742	185.97%
Нийт дүн	10,499,000,000	10,499,000,000	100%

Зарцуулалтын төлөвлөгөөний дагуу 2025.03.31-ний байдлаар

15

9. Ногдол ашгийн мэдээлэл

2024 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 2.6 төгрөг буюу нийт 3.1 тэрбум төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан тарах шийдвэр гаргасан.

10. Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Ганбат

Албан тушаал: “Газар шим үйлдвэр” ХК-ийн

Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: *Б. Жагшсүр*

Албан тушаал: *Бронхий менежер*

Гарын үсэг: *[Signature]*

/тамга тэмдэг/